



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 16

Номгон

**Зоорь барих төсөл дэмжих тухай**

Баянхонгор аймгийн хэмжээнд 4,587,738 сая мал тоологдож, үүний дотор адуу 180,128, тэмээ 54,349, үхэр 24,342, хонь 1,381,125, ямаа 2,731,794 байна. Эдийн засгийн тэргүүлэх салбар болсон мал сүрэг ийнхүү өсөж байгаа хэдий ч түүнээс гарч буй бүтээгдэхүүний үнэ харьцангуй доогуур, малчдын орлого нэмэгдэхгүй байгаа нь мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортод чиглэсэн үйлдвэр байхгүйтэй холбоотой. Мөн мах, махан бүтээгдэхүүний ханш улирлын чанартай хэлбэлзэж тогтворгүй байгаа нь стандартын дагуу хадгалах зоорьгүйгээс шалтгаалж байна. Төмс хүнсний ногооны үнэ намрын улиралд хямдарч, өвөл хаврын улиралд эрэлт нь ихсэж, гаднаас импортоор орж ирж байгааг зогсоож орон нутгийн тариаланчдыг бодлогоор дэмжих шаардлагатай байгааг ТЭМДЭГЛЭЭД :

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 2 дугаар бүлгийн 80 дахь заалт, аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлийн 125 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг дарга Г.Батжаргалд ДААЛГАХ нь :

1.1. Аймгийн хэмжээнд малын гаралтай бүтээгдэхүүн хадгалах хөргөлттэй зоорь, төмс, хүнсний ногооны стандартад нийцсэн ердийн халаалттай зоорь барих хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн санаачлагыг дэмжиж үйл ажиллагааг нь чиглүүлж ажилласугай.

1.2. Төслийг дэмжигч олон улсын байгууллагууд, донор улс орнуудын элчин сайд, консулын газар, өргөмжит консул, бусад газруудад хандаж хөрөнгийн дэмжлэг үзүүлэх, буцалтгүй тусламж олгохыг хүссэн санал боловсруулж холбогдох газруудад хүргүүлэхийг үүрэг болгосугай.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж Зоорь барих ажлын эхлэл, явц үр дүнгийн талаар мэдээлэл бэлтгэж 2018 оны 2 дугаар улиралд багтааж аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА  Ц.ОТГОНБАЯР